

САНСКРИТ СУДЛАЛЫН ТҮҮХЭЭС

М. Саранцэцэг

Энэтхэгийн уран зохиолын нэн эртний дурсгал бичиг вед шастир хэмээх дөрвөн аймаг дуулал болон хоёр мянган жилийн тэртээ зохиогдож эртний энэтхэгийн ахуй амьдрал, зан заншил, үзэл санааны ойлбор болсон «Махабхарата», «Рамайна» их туульс, түүнчлэн Шидэт хүүрийн үлгэр», «Гучин хоёр модон хүний үлгэр», «Таван сургамж» үлгэрийн их цоморлигс, «Үүлэн зардас» уянгын шүлэг найргийн зүйл, жич бурхны олон цадиг зэрэг дэлхий дахинаа алдаршсан үлэмжхэн бүтээлийг эртний Энэтхэгийн бичгийн их хэл болох санскрит хэлээр туурвисан билээ.

Эртний түүхт энэ хэл хүн төрөлхтөний соёл иргэншлийн уг гарал, түүх намтартай холбогдох үлэмж нууцыг хадгалсаар байгаа хэдий ч түүнийг судлагч эрдэмтэн мэргэдийн эрэл хайгуул бас ч талаар өнгөрсөнгүй, алхам алхамаар тэрхүү нууцад нь нэвтэрсээр өнөөг хүрчээ.

Санскрит хэлийг судалсан хэлзүйч олон бөгөөд МЭӨ II зуунд Батанжали, IV зуунд Банини нар хэлний зүйн дүрэм боловсруулсан нь төгс болсноороо өнөө ч хэл шинжээчдийг бишрүүлдэг байна. «Санскрит» гэдэг үг өөрөө «сайтар боловсруулсан» хэмээх утгатай ажээ. Санскрит хэлээр бичсэн уран зохиол, бурхан шашин, гүн ухаан, түүх шастир, хууль цааз, анагаах ухааны олон ном зохиол нь уг эхээрээ буюу орчуулгаараа, эсвэл засаж янзалсан байдлаар уламжлан ирэхдээ дэлхий дахины соёлын хөгжил цэцэглэлтэд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж, зөвхөн энэтхэгийн төдийгүй, Ази, Европын олон орны уран зохиолыг уран сайхны үнэт зүйлсээр баяжуулж, мянга мянган жилийн турш энэтхэгийн ард түмний оюун санааны амьдралд нөлөөлсөөр ирсэн билээ. Тэгээд ч энэхүү хэлээр бичсэн соёлын арвин баялаг өвийг судалж анхаараагүй улс түмэн цөөн биз ээ. Нэрт энэтхэг судлаач Вильям Браун, санскрит хэл бол билиг авьяас төгөлдөр уран гартны эх бүтээлээс цогцлон сүндэрлэсэн бөгөөд бүхий л хэсгийнх нь бишрэм шүтэлцээ нүднээ илхэн тусах орд өргөө мэт агаад шинжлэн судлах тусам урам, хүч хайрлаад байдаг хэл санскритаас өөр бий эсэхийг би ер үл мэдэх ажим гэсэн байдаг нь аргагүй л санскрит хэлийг судлахад бие сэтгэлээ зориулж, түүнээс эгшиглэх аялгууг мэдрэн ойлгож байсан их эрдэмтний үг гэлтэй.

Санскрит хэлээр бичсэн бүтээлүүд дэлхийн улс түмэнд ямар замаар хэрхэн тархсан түүх, ялангуяа өргөн уудам Ази тивд түгэн дэлгэрсэн жим замыг нэхэн санахад сонин юм. Японд санскритийн гар бичмэлүүд Солонгосоор дамжин VI зуунд хүрсэн гэх бөгөөд өмнөд Энэтхэгийн Бодисена гэгч брахман VIII зуунд Нара хотын сургуульд анх санскрит хэлийг зааж эхэлсэн гэж үздэг байна. IX зуунд Японы гэлэн Кобо Дайши санскрит цагаан толгойд үндэслэн үе үсэг зохиож улмаар нэгэн найраглал бичсэний нь Японы багачуул одоо хүртэл үзсээр байдаг аж. 1879 онд Токио дахь эзэн хааны их сургуульд бүддийн сургаалийн талаар цуврал яриа уншлага болсон нь яваандаа энэтхэгийн гүн ухааныг судлах байнгын төв болжээ. Индонезийн хувьд гэвэл, энд санскритаар нэрлэсэн барилга байшин, албан газар элбэг байдаг гэнэ. Филиппинд тагалог болон бусад хэлний зэрэгцээ нутгийн

аялгуудад санскритаас орсон үгс цөөнгүй байгааг эрдэмтэд судалж тогтоожээ. Бирмийн ард түмний хэл бичиг, уран зохиол, сүсэг бишрэлд санскрит хэл үлэмж их нөлөөлсөн бөгөөд, «брим» гэдэг нь санскритийн «брахма» хэмээх үг гэж үздэг байна. Мөн энэ улсын хэд хэдэн хот, муж санскрит нэртэй ажээ. Санскрит хэлийг Европ тивд судалж эхэлсэн нь харьцангуй саяхных гэж үздэг бөгөөд одон орон, тоо бодлого болон анагаах ухааны бүтээлүүд Иран болон араб дахинд түгэн тархаж тэндээсээ Европт нэвтэрчээ. XVI зууны сүүлээр англичууд Европын санскрит судлалыг нэлээд лавшруулсан байна. Эрдэмтэн Чарльз Вилкинс (1749—1836) эртний энэтхэг бичээсүүдийг тайлан уншиж, Гита-г англи хэлнээ хөрвүүлсэн санскрит хэлний төгс мэдлэгтэй анхны англи хүн байжээ. Вильям Жонс (1746—1794) Азийн түүх сурвалж, эд өлөг, соёл урлаг, шинжлэх ухаан, хэл яриа, уран зохиолыг судлах нийгэмлэгийг 1784 онд Калькутта-д үүсгэн байгуулж, Галидасын «Үүлэн зардас»-ыг анх түрүүн англи хэлнээ орчуулжээ. Тэрбээр, санскрит хэл нь грек хэлнээс төгс төгөлдөрөөрөө, латин хэлнээс арвин баялагаараа давж гарах бөгөөд эдгээр хэл нь нарийн тансагийн хувьд ч санскрит хэлтэй эн зэрэгцэхгүй болохыг бахархан бичиж байлаа.

XVIII зууны эхээр санскрит судлалыг шургуу шамдан хөгжүүлсэн улс бол Франц юм. Тэд Европ тивдээ ууганд тооцогдох санскрит судлалын тэнхимийг 1814 онд нээн ажиллуулсан нь өрнөдөд дорнодахиныг судлах анхны газар болсон байна. Санскрит судлалын хоёр дахь өлгий гэгддэг Герман улсын эрдэмтэн Хенрик Рот (1650), Иоханн Ханкслэдэн (1699—1732) нар санскрит хэлний зүйг Европт анх боловсруулсан хэдий ч энэтхэг судлалыг Германд шинжлэх ухааны үндэс суурьтай анх хөгжүүлсэн хүмүүс бол ах дүү Шлегелем хэмээн зүй ёсоор үздэг байна. Ах Август Шлегелем (1767—1845) нь энэтхэг судлалын тэнхимийг Германы их сургуулиудаас анх түрүүн байгуулсан Бонны их сургуульд ажиллаж байжээ. Оросын анхны энэтхэгч эрдэмтэн бол Герасим Степанович Лебедев (1749—1817) юм. Тэрбээр, санскрит хэл нь зөвхөн Азиар үл барам Европын олон хэлтэй хэлний зүйн талаар үлэмж төстэйг ажиглаж, санскрит хэлийг орос хэлтэй харьцуулан судлахад анхаарлаа хандуулсан байна. Оросын санскрит судлалын анхны тэнхим 1842 онд Казанийн их сургуульд, удаах нь 1855 онд Санкт-Петербург хотноо ажиллаж эхэлжээ. Рот-Ботлинк нарын зохиосон санскрит-герман 7 боть толь бичгийг Санкт-Петербург хотод 1852—1875 онд хэвлэсэн нь санскрит судлалд оруулсан жинтэй хувь нэмэр болжээ.

Америкийн анхны санскритч эрдэмтэн Эдвэрд Селисберн XIX зууны дунд үед Йелийн их сургуульд судалгаагаа эхэлжээ. Түүний шавь Вильям Витни нь Атхарваведийн тухай бүтээлээрээ алдаршсан бөгөөд 1854 онд уул их сургуульд санскрит судлалын профессор цолыг хүртсэн нь Америкт анхных нь байлаа. Энэ мэтчилэн санскрит судлал Итали, Голланд, Чех, Мажар, Польш, Швейцар зэрэг олон оронд хөгжиж, Дани, Швед, Норвеги, Португали, Испани болон бусад улс судалгааны төвтэй болжээ. Софи, Ленинград, Токио, Загреб, Любляны их сургуулиудад санскрит хэл зааж байгаа аж.

Латин Америкт санскритийн судалгаа 1940-өөд оноос эхэлсэн бөгөөд эдүгээ Мексик, Коста-Рика, Чили, Перу зэрэг улсад санскрит хэлийг судалж байна.

Хүмүүс ихэнх нь энэхүү хэлийг мөхөж утсан хэлд тооцоод, одоо энэ хэлээр хэн ч ярихгүй болж, урьдын ном судар л уламжлан ирээд санскрит гэдэг нэр зөвхөн түүх болон үлдэж дээ гэж боддог байна. Тэгвэл энэтхэг улсын тухайд байдал их өөр аж. Энэтхэгийн ард түмэн

эртнийхээ бичиг соёлоороо бахархан, утга зохиолын дурсгалаа эрхэмлэн хүндэтгэж, хайрлан хамгаалдаг сайхан заншилтай билээ. Энэтхэгийн эрдэмтэд ч энэ талаар их ажил хийж иржээ. Эртний ном судар үрэгдэж үгүй болохоос сэргийлэн хамгаалах, гадна дотны олон эрдэмтэн үзэж судлахад нийцүүлж хэвлэх, нийтлэх зэрэг ажил эрхлэх Энэтхэгийн соёлын олон улсын хүрээлэнг 1934 онд доктор Рагу Вира, дорно өрнийн нэрт энэтхэгч эрдэмтэдтэй хамтран байгуулсан билээ. Жич өгүүлэхэд, Рагу Вира доктор 1959 онд хуралдсан олон улсын монголч эрдэмтний анхдугаар их хуралд хүрэлцэн ирж, «Монголын агуу их утга зохиолыг дэлхий дахинд танилцуулья» илтгэл тавьсан нь үнэхээр монголын ард түмний соёлын өв уламжлалыг эрхэмлэн хүндэтгэж буй сэтгэлийн үг нь байсан билээ. Тэрхүү хүрээлэн нягтлан судалж үзээд дэлхийн улс түмний номын санд санскрит хэлээр бичсэн гурван бумаас наашгүй бичмэл ном судар хадгалагдаж буйг тогтоожээ.

Энэтхэгийн анхны үндсэн хууль боловсруулах үед (1946-1949) хэлний асуудлыг хэлэлцсэн хурал үргэлжилсэн хугацаа, өрнөсөн маргаанаараа бусдаасаа ялгарсан бөгөөд санскрит хэлийг төрийн хэлний статустай болгох асуудлыг хэлэлцжээ. Хэлний асуудал намын дотор болон намуудын хооронд ширүүн маргаан дэгдээж байна. Эцэст нь санскрит хэл улсын 14 гол хэлний нэг (одоо 15) болж өнөөдөр шинжлэх ухааны эрчимтэй хөгжлөөр шинэ тутам бий болсон ойлголт, ухагдахууныг оновчтой зөв томъёолон нэрлэх гол хэрэглүүр болж байна. Одоо Энэтхэгт 2,5 мянган хүн санскритийг эх хэлээ, 2 бум илүү хүн хоёрдох хэлээ гэж үзэж байна. Энэтхэгийн олон их дээд сургуульд санскрит хэлний тэнхим ажиллаж 500 гаруй сайн дурын байгууллага уг хэлийг сурталчлах, дэлгэрүүлэх ажил эрхлэхийн зэрэгцээ судалгаа шинжилгээний нөр их ажил хийж байна. Аллахабад дахь санскритийн их сургууль эртний гар бичмэлийг эрэн сурвалжилж эдүгээ номын сан хөмрөгт нь урьд өмнө хувь хүний цуглуулганд байсан 50 мянга гаруй үнэлж баршгүй гар бичмэл хадгалагдаж байна. Санскрит хэлийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж заншсан хүн ч байдаг аж. Дели хотод Кришна Шаст гэгч залуу хэвлэлийн бага хурал хийлгэн эхлэхээс нь дуустал санскрит хэлээр өөрөө хөтлөн явуулсан нь олны анхаарлыг ихэд татаж хэвлэл мэдээллийнхнийг шуугиулсан гэнэ. Тэрбээр, санскрит хэл олон үндэстэн ястан ойртон нягтрах хэрэглүүр гэж үздэг бөгөөд унаа тэрэг, төмөр зам, гудамж талбай, зах зээл ер нь хаа ч явсан энэхүү хэлээр ярьдаг гэнэ. Эгэл жирийн олон түмэнтэй ийнхүү харилцан ярихад бэрхшээж төвөгшөөх зүйл огтхон ч гардаггүй гэж тэр залуу сэтгүүлчдэд ярьжээ. 1986 оны хавар Тамилнад «Өнөөгийн Энэтхэг дэх санскрит уран зохиол, санскритийн үүрэг» сэдэвт бага хурал хуралджээ. 1987 оны намар Дели хотноо хүний хүчин зүйлийн хөгжлийн яам, санскритийн үндэсний их сургуулиас санскритийн өдрийг зохион явуулжээ.

Санскритийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж дэлгэрүүлж байна. Энэ хэл дээр 30 гаруй тогтмол хэвлэл, үүнд 15 мянга шахам хувь хэвлэгддэг 7 хоног тутмын 2 сонин гардаг байна. Санскрит хэлээр улсын бараг бүх том радио станц нэвтрүүлгээ явуулж байна. Эртний энэтхэгийн энэ хэлийг шинжлэх ухаан, уран зохиолын судлал шинжилгээнд өргөн хэрэглэж, эрдэмтэн мэргэд зохиол бүтээлээ туурвиж байна. Бомбейгийн хоёр хэвлэлийн газар эртний санскрит бичиг шастир хэвлэх, дахин хэвлэх ажлыг дагнан эрхэлж байгаа бөгөөд энэхүү хэлээр туурвисан зохиол бүтээлийг улсын олон тооны хэвлэлийн газар хэвлэдэг ажээ. Энэтхэгийн засгийн газар санскрит хэл болон санскрит судлалд ихээхэн анхаарал тавьж уг хэ-

лээр бүтээн туурвигчдыг дэмжин урамшуулж, хөхүүлэн шагнадаг бөгөөд Энэтхэгийн уран зохиолын академийн шагнал хүртэгсдийн дотор санскритаар бичдэг зохиолч цөөнгүй бий. Мөн дэлхийн сонгодог уран зохиолын зүйлээс орчуулж хөрвүүлэх их ажлыг өргөн дэлгэр хийж байна. Саяхан эрдэмтэн Мохан Гупта Шекспирийн зохиолыг санскрит хэлнээ орчуулжээ. 1983 оны 6 сард Энэтхэгийн болон дэлхийн кино урлагийн түүхнээ анх удаа санскрит хэл дээр Шанкарачарья гэдэг кино бүтээсэн бөгөөд VIII зуунд амьдарч байсан их сэтгэгч Шанкарын тухай өгүүлдэг аж. Ийнхүү, одоо ч санскрит хэл хүмүүсийн хоорондын харилцааны хэрэглүүр болсон хэвээрээ л байна.

Эртний түүх соёлт Энэтхэг оронтой монголчууд өнө эртнээс холбоо харилцаатай явж ирсэн бөгөөд урлаг соёл, аж байдлын зүйлд энэтхэгийн соёл, заншлаас шингэн үлдсэн ул мөр нэн арвин болохыг судлаач шинжээчид олонтаа тэмдэглэсэн билээ. Манай эриний өмнөх V зууны сүүлээр эмхэтгэсэн энэтхэгийн зарим зохиолд Хүннү нарын нэрийг дурдсан байдгийг манай эрдэмтэд бичсэн нь бий. Энэтхэгт үүссэн бүддийн шашин Монголд манай эриний өмнөх үед анх нэвтэрч гүнзгийрэн III—VIII зууны үеэс Монголын Тоба улс, Түрэгийн хаант улсын цагт Монгол газар бүддийн сүм дуган барьж байгуулах ажил дэлгэрч байсныг аянчин жуулчид, жич V зууны үед энэтхэг газар тойрон явсан хятад жуулчин Фа Сянь, VIII зууны үед мөн түүгээр явсан Хятадын эрдэмтэн Сюань Жуан (Тансан лам) нар Монголын их говийг туулж гарах замд тэр цагийн монгол аймгуудын нутагт буддийн шашны сүм дуган олныг үзэж, олон мянган лам хурал хурахыг сонсож, энэтхэг хэл сурч, энэтхэгээр ном уншиж байхыг харав гэж тэмдэглэлдээ бичсэн нь бий аж.

Энэтхэгийн эртний соёлын дурсгал, Бурхны шажны ном зохиолын агуу их цоморлиг «Ганжуур», «Данжуур» (энэтхэг оронд Трипитака), монголоор бол «Зарлигийн орчуулга», «Шастирын орчуулга») хоёрыг монголын эрдэмтэн орчуулагчид XIV зууны эхээр монгол хэлнээ хөрвүүлээд модон бараар хэвлэж байсан байна. Монголчууд энэтхэгийн бурхан шашны болоод бусад ном судраас ихэнхдээ төвдөөр дамжуулан орчуулсан гэдэг ба «их хөлгөн лагшин эрдэнэт гэтэлгэгч» «их нирвааны номын магтаал» «их хөлгөн тус эрдмийн ном» зэрэг олон номыг эх хэлнээс нь монголчилсон мэдээ байдаг. Энэтхэгийн Бахаа бандид (Чулуун хуруут азар) гэдэг их бага хоёр эрдэмтэн Монголын хааны ордонд санскрит хэл зааж, «Шидэт хүүрийн үлгэр» тэргүүтэн иргэний гайхамшигт зохиолыг дэлгэрүүлж байсан байна. Ингэж манай монголчууд Энэтхэг зүгийн үлгэр домгийн зүйлээс бичиг судартаа шигтгэн оруулахын зэрэгцээ аман зохиол мэтээр хэлэлцэж, тэр нь амнаас ам дамжин явахдаа маш сонин сайхан найруулгатай болон боловсорч тэр нь ном бичигт тэмдэглэгдсэнээсээ илүү тансаг, сонирхолтой болдог удаа байжээ. Манайхан «Бигармижид хааны тууж», «Гэснэ хааны тууж». «Гучин хоёр модон хүний үлгэр» бас «Шидэт хуурийн үлгэр» зэргийг үе дамжин хэлж ярьсаар ирсэн бөгөөд Жагарын орон гэж Энэтхэг газрыг хэлдэг юм байна гэж тэртээ дээр үеэс тэрхүү үлгэр туужийн зүйлээс мэддэг байжээ. Бас монголын хаад, орчуулагч нарт туслахын тулд Энэтхэг орноос санскрит хэлний мэргэжилтэн нарыг урин ирүүлж, тэд монголчуудын суралцахад зориулж санскрит хэлний зүй, сурах бичгийг зохиож байсан байна. Монголчууд энэтхэг, төвд үсгийг нарийн тэмдэглэдэг байжээ. Аюуш гүүшийн 1587 оны үед зохиосон «Энэтхэгийг арван зургаан эгшиг хийгээд гучин дөрвөн гийгүүлэгч үсгүүд гишүүн лүгээ сэлт оршивай» хэмээгч энэтхэг үгийг монголоор галиглан бичиг үсгийг Монгол үсэгт нэмэн зохиож шинжлэх

ухааны нарийн бичиглэл хийх болсон нь бараг 200-аад жилийн хойно Европын эрдэмтдийн боловсруулж латин галиг хийсэнтэй зарчим яг ижил байдаг нь үнэхээрийн тэрхүү багшийн эрдэм билгийн ид хав, монголчуудын бичиг соёлын өндөр хөгжлийг үзүүлсэн бас нэг жишээ юм. Монгол газар энэтхэгийн ланз, төвдийн шар сав, монголын соёмбо үсгийн сургууль хийдэг байсан нь 1924 он хүртэл хэд хэдэн газар байжээ. Энэтхэгийн их соёлын зүйлс Монгол газар түгэн дэлгэрэхдээ урлаг, уран зохиол, ахуй амьдралд гүн нөлөөлсөн нь улмаар монгол үгсийн санг санскрит үгээр баяжуулах үндсэн нөхцөл болсон билээ. Бидний сайн мэдэх шашин, судар, мутар, эрдэнэ, шүлэг, бадаг, увидас, дагина гэх юм уу эсвэл шарил, шаштир, гариг, зул гээд өдий төдий үг санскрит хэлнийх бөгөөд өнгөрсөн хэдэн зуун жилийн турш монгол хэлэнд орсон тэдгээр үг үгсийг түүж бичвэл, орос хэлэнд латин үг орсоны дайтай лав бий гэж судлаачид үздэг нь тун ч ортой юм.

Ийнхүү санскрит хэл Монголын номын хэл болж, монголчуудын оюун санааны амьдралд маш их нөлөө үзүүлсэн билээ. Монголын эрдэмтэн, зохиолчид ч эртний энэтхэгийн шинжлэхүй ухааны төрөл бүрийн салбараар туурвисан үлэмж бүтээлийг санскрит, төвд хэлээр нь судалж, ном зохиолыг нь орчуулж түмэн олондоо танилцуулж байсныг бодоход нэн бахархмаар. Ийн орчуулан хөрвүүлэхээс гадна тайлбар зохиол туурвин бичдэг их уламжлалтай ажээ. Үүнд эртний энэтхэгийн яруу найргийн онолч Дандины «Зохист аялгууны толь»-ийг халхын Жавзандамба хутагтын шавь гүүш Гэлэгжалцан XVIII зуунд төвдөөс монгол хэлнээ орчуулж, Сүмбэ хамбо Ишбалжир, Жамъян гарав зэрэг олон монгол эрдэмтэн тайлбар хийжээ. Энэхүү санскрит хэлний яруу найргийн онолын бүтээлийн төвд, монгол тайлбар түүний түгэн дэлгэрсэн байдлыг акад. Ш. Бира, адилтгал, зүйрлэлийг эрдэмтэн Х. Гаадан судалсан бол эрдэмтэн Л. Хүрэлбаатар XIX зууны үеийн Монголын яруу найргийн онолч Жамъянгаравын тайлбарыг Төвд, Монголын эрдэмтдийн (V Далай лам Лувсанжамц, Лав Жамган Лувсандамбачойнпил, Агваантүвдэн, зохиосон бусад хэд хэдэн тайлбартай харьцуулан судалж байна.

Акад. Ц. Дамдинсүрэнгийн олон бүтээл энэтхэг, төвд, монголын судлалын нийтлэг асуудалд хандсан бөгөөд ялангуяа «Рамаяна Монголд дэлгэрсэн нь» зохиол онцгой байр эзэлдэг билээ.

Энэтхэг, Төвд үлгэр туужийн зохиолыг монгол ахуй нөхцөлд дээшлүүлэн боловсруулсныг доктор Д.Ёндон судалж ном хэвлүүлжээ.

Ийнхүү манай эрдэмтэд энэтхэг, төвд, монгол уран зохиолын хэлхээ холбоог шамдан судалж байгаа нь зөвхөн уран зохиолын төдийгүй монголчуудын ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний онцлогийг тодруулах чухал асуудалтай холбогдож байгаагаараа бүр ч үнэ цэнтэй юм.